



ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН 2025

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК



(976) 7021-0167



baganuur@bnedo.mn



АГУУЛГА

НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР.....	4
2.1. Хүний нөөцийн бодлого, шилжилт хөдөлгөөн	5
2.2. Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:.....	7
2.3. Хүний нөөцийн судалгаа	9
2.4. Хууль, эрх зүйн чиглэлээр	10
2.5. Сургалтын чиглэлээр	11
ГУРАВ. ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	13
3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар	13
3.2. Дотоод хяналт, шалгалт	14
ДӨРӨВ. ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	17
4.1. Техникийн нөхцөл олголтын талаар:	17
4.2. Ашиглалтын талаар:	18
4.3. Засварын ажлын талаар	21
4.4. Хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах чиглэлээр	33
4.5. Урсгал засварын ажлын талаар	34
4.6. Горимын талаар	37
4.7. Шуурхай ажиллагааны чиглэлээр	41
ТАВ. ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.....	48
5.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч	48
5.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч	50
5.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал	50
5.4. Цахилгаан эрчим хүчний авлага	51
5.5. Хэрэглээний бүтэц, хэрэглэгчийн тоо	51
5.6. Хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлт, дуудлагын судалгаа	52
5.7. Тоолуур, хэмжүүрийн чиглэлээр	53
ЗУРГАА.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.....	55
6.1. Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гүйцэтгэл.....	55
6.2. Дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа.....	56
6.3. Сангийн яаманд гаргасан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал.....	57
ДОЛОО. 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ.....	58



АЛСЫН ХАРАА

Бид дэлхийн жишигт хүрнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол орны зүүн өмнөд бүсийн хөгжлийн хөтлөгч нь байж, хэрэглэгчдэд чанартай цахилгаан эрчим хүчийг тасралтгүй ханган түгээгч, хэрэглэгч, хамт олноо дээдэлсэн тэргүүлэх компани байх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС

Хэрэглэгчдээ дээдлэх
Хуулийн хүрээнд ажиллах чадвар
Ил тод шударга байдал
Чанар хариуцлага
Сахилга бат
Мэргэжлийн ур чадвартай, бүтээлч байх
Хуримтлуулсан ажлын туршлага



НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тус компани нь анх Бүгд найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 328 дугаар тогтоолоор “БАГАНУУР ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР” нэртэйгээр байгуулагдсан. Монгол Улсын Их Хурлаас Эрчим хүчний тухай хуулийг 2001 онд шинэчлэн баталж, эрчим хүчний байгууллагуудыг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрлийн эрх бүхий бие даасан компаниуд болгон шинэчлэн байгуулснаар Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 164 дүгээр тогтоолоор “БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК болж бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдсөн.

Тус компани нь ашиглалт үйлчилгээний заагаар хойд тал нь Хэнтий аймгийн Дадал сумаас урд тал нь Дорноговь аймгийн Ханги хилийн боомт хүртэл, зүүн тал нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас, баруун тал нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сум хүртэл, нийт 276.6 мянган км² газар нутаг дахь нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төв, 7 аймгийн 58 сум, суурин газрын нутаг дэвсгэрт байрлах 559068 хэрэглэгчид дараах дараах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Цахилгаан түгээх
2. Цахилгаанаар зохицуулалттай хангах;
3. Цахилгаан импортлох (БНХАУ)-аас
4. 0.4-220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ
5. Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын цахилгааны тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах
6. Эрчим хүчний барилга байгуулмжийн зураг төсөв боловсруулах

Тус компани нь дээрх тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд түгээх, хангах үйл ажиллагааны чиглэлээр 784.6 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг худалдан авч, худалдан авсан цахилгаан эрчим хүчний 5.03% буюу 39.4 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг түгээлтэд алдаж, 745.1 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээн борлууллаа.


0,4–220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд 110 кВ-ын 2, 35 кВ-ын 46, 22кВ-ын 2, 20.2/0.22 болон 6/10/15 кВ-ын 519, нийт 569 дэд станц, 4487.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 170.3 км кабель шугамын ашиглалт, засварын ажлыг хариуцан ажиллаж байна.

Цахилгаан, соронзон хэмжлийн хэмжих хэрэгслийг суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд компанийн нийт ахуйн болон үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага, дэд станцуудын 1 ба 3 фазын цахилгаан эрчим хүчний тоолуурууд, гүйдлийн трансформаторууд, хэмжүүр хэмжих хэрэгслүүд, хэмжүүрийн багажуудын шалгалт, тохируулгыг хийж гүйцэтгэн эдгээрийн баталгаажуулалтыг Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газар болон тус газрын аймаг орон нутаг дахь салбаруудтай хамтран гүйцэтгэж байна.

Цахилгаан импортлох тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд Дорноговь аймгийн Ханги хилийн боомтоор БНХАУ-аас 3.1 сая.кВт*ц цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авсан байна.

ХОЁР. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсны дагуу орон тооны дээд хязгаар 565, зохион байгуулалтын бүтцийн хувьд 5 салбар, 7 хэлтэс, 5 албаны нийт 544 ажилтантайгаар компанийн чиг үүргийг хэрэгжүүлэв.



Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Эрчим хүчний яаманд хүсэлт гаргасны дагуу “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах” болон “220кВ ба түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлүүдийг шинээр авснаас гадна дараах сургалтуудыг явуулах эрх авсан. Үүнд:

1. Ажил олгогчийн ХАБЭА-н сургалт
2. Нийт ажилтны ХАБЭА-н сургалт
3. ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалт
4. Цахилгааны аюулгүй ажиллагаа
5. Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

Үндсэн бус үйл ажиллагааны орлого зардлын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалтын журмыг батлан, сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс тооцоход ажлын гүйцэтгэлийг бодитой тооцох, цахилгаан эрчим хүчний төлбөрийн алданги тооцох журмыг шинэчлэх зэрэг зохион байгуулалтын томоохон ажлуудыг хийсний үр дүнд үндсэн бус үйл ажиллагааны орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 564.4 сая төгрөгөөр буюу 36.2 хувиар давуулан биелүүллээ.

Шуурхай ажиллагааны дүрэм, журмуудыг шинэчлэн баталсны дагуу техникийн нөхцөл олголт, шинэ хэрэглэгч холбох журмуудыг, захиалга үйлдэх, сэлгэн залгалт хийх зэргийг оновчтой, эрсдэл багатай болгосноор хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчилж, таслалтын хугацаа багассан бөгөөд харьяа салбарууд үйлчлэх хүрээний бүс нутаг дахь аж



ахуйн нэгж байгууллагуудтай ашиглалт засварын гэрээ байгуулж, хэрэглэгчийн эзэмшлийн шугам, тоноглолд засвар үйлчилгээг хийх боломжийг бүрдүүлснээр нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа Исайди-719 минут буюу 81 минутаар буурсан.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын “ISO 45001:2018” менежментийн тогтолцоо, стандартыг Төв компанийн хэсэг, Багануур, Хэнтий салбаруудад амжилттай нэвтрүүлж, нэгдүгээр үе шатны баталгаажуулалт амжилттай хийгдлээ. 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхдугаар зөвлөгөөнийг компанийн хэмжээнд зохион байгуулан, Багануур, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь цахилгаан түгээх сүлжээ салбарын 280 гаруй ажилтнуудыг оролцуулж, 14 заалт бүхий зөвлөмж гарган, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дэлхийн банкны санхүүжилтийн зээлийн эх үүсвэрээр “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд бий болсон 25.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэх асуудлыг ТӨБЗГ-ын 2025 оны 12 сарын 04-ний өдрийн 661 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлж, Нягтлан бодох бүртгэлд тусгах ажлыг эхлүүллээ. Компанийн үйлчлэх хүрээний 4 аймгийн төв, 57 сум суурин газрын хэрэглэгчдийг 2026-2027 онд ухаалаг тоолуурын системд 100 хувь холбох төслийн техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөл болон Эрчим хүчний зохицуулах хорооны хурлаар хэлэлцүүлж, 7.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлснээс гадна HOLLEY брендийн ухаалаг тоолуур, мэдээлэл цуглуулагчийн “HES” системийг суурилуулан, борлуулалт арилжааны системтэй холбох туршилтыг амжилттай хийснээр Ухаалаг тоолуурын систем болон хангамжийн хувьд нэг үйлдвэрлэгчийн хараат байдлаас гаргаж, ухаалаг тоолуур, өгөгдөл цуглуулагчийн үнийг 15-35 хувиар бууруулан зах зээлд чөлөөт өрсөлдөөнийг бий болголоо.

Тус компанийн хэмжээнд албан хэргийг цаасан хэлбэрээр хөтөлж байсныг Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, албан бичгийг шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2025 оны 10 дугаар сараас эхлэн Able систем нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийг цахимд шилжүүлж, компанийн менежментийг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх зорилгоор 2025 онд нийт 13 дүрэм, журам, зааврыг шинэчлэх буюу шинээр боловсруулж баталсан.

2.1. Хүний нөөцийн бодлого, шилжилт хөдөлгөөн

Тайлант хугацаанд компанийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулан, давхардсан чиг үүрэг бүхий хэлтсүүдийг нэгтгэж Хяналт аюулгүй ажиллагааны хэлтсийг шинээр байгуулан, салбаруудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтны тоог нэмэгдүүлснээр тулгамдаж буй асуудал болох хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг сайжрууллаа.

Мөн компанийн үйл ажиллагааны төлөвлөлтийг эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллахад чиглүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийг шинээр байгуулснаас гадна ажлын ачаалал бага, хэрэглэгчийн тоо цөөн болон технологийн шийдлээр хүний оролцоогүйгээр гүйцэтгэх боломжтой 12 ажлыг байрыг цөөрүүлж, шаардлагатай орон тоонд шилжүүлснээр 600.0 сая төгрөгийн хэмнэлт гаргалаа.

Дуудлагын төвийн үйлчилгээг харьяа салбаруудад шилжүүлж, дуудлага мэдээллийн мэргэжилтний орон тоог бий болгосноор компанийн хэмжээнд 12 шугамаар хэрэглэгчдийн дуудлагыг хүлээн авч, дуудлагыг түргэн шуурхай барагдуулан, компани болон харьяа салбаруудын цахим хуудсуудыг олон нийтэд хүртээмжтэй болгон хандалтыг нэмэгдүүлж, хөгжүүлэлт хийлээ. 2025 оны байдлаар дуудлагын нэгдсэн системд нийт 272 мянган

хэрэглэгч хандсанаас 225 мянган хэрэглэгч амжилттай холбогдсон бөгөөд хэрэглэгчийн санал гомдлыг хэрхэн шийдвэрлэж буйг үнэлэх, ажлын үр дүнд тооцох зохицуулалтыг нэвтрүүлээ.


Компанийн хэмжээнд 2025 онд шинээр 112 ажилтан томилогдож, 89 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, компани болон салбар дотроо ажлын байр нь өөрчлөгдсөн 136 ажилтан байна.

Гүйцэтгэх захирал болон харьяа салбарын даргын тушаал (2022-2025 он)

Д/д	Он	2022 он		2023 он		2024 он		2025 он	
	Нийт орон тоо	555		555		555		565	
	Ажилтны тоо	548		529		531		544	
	Тоон үзүүлэлт	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Ажилд шинээр томилогдсон	181	33.0	115	21.7	111	20.9	112	20.6
2	Ажлын байр, албан тушаал өөрчлөгдсөн	192	35.0	101	19.1	73	13.7	136	25.0
3	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан	175	31.9	116	21.9	131	24.7	89	16.4
4	Сахилгын шийтгэл ногдуулсан	62	11.3	115	21.7	87	16.4	54	9.9
5	Ажлын 5 хоногоос дээш чөлөө олгосон	158	28.8	217	41.0	161	30.3	202	37.1

Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны тоо өмнөх оноос 42 нэгжээр, шилжилт хөдөлгөөний хувь өмнөх оноос 8.3, сүүлийн 3 жилийн дунджаас 9.8 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байгаа ба ажлаас гарсан ажилтнуудын дийлэнх буюу 66 хувийг бага тушаалын ажилтнууд эзэлж байна.

Нийт ажилтны шилжилт хөдөлгөөн (2022-2025 он)



Шилжилт хөдөлгөөнийг ажил мэргэжлийн бүлэг индексээр харьцуулсан байдал (2022-2025 он)


Д/д	Он	2022 он	2023 он	2024 он	2025 он
		Ажилтны тоо	548	529	531



1	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд-нийт	74	179	133	89
2	Удирдах албан тушаалтан	4	2	5	5
	Хувь	5%	1%	4%	6%
3	Инженер техникийн ажилтан	46	46	39	17
	Хувь	62%	26%	29%	19%
4	Албан хаагч	14	9	15	8
	Хувь	19%	5%	11%	9%
5	Бага тушаалын ажилтан	10	122	74	59
	Хувь	14%	68%	56%	66%

Хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгцээнд үндэслэн тус компанийн хэлтэс, алба, нэгжийн удирдлагууд нь шаардлагатай байгаа сул болон шинээр бий болсон ажлын байрны захиалгыг “Хүний нөөцийн захиалга өгөх хуудас”-аар Захиргаа хүний нөөцийн хэлтэст ирүүлснээр Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаартай тушаалаар батлагдсан “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан ажлын байрны нөхөн дүүргэлт 0.8 пунктээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сул орон тоо (2023-2025 он)



2.2. Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:

Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан “Хамтын гэрээ”, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төрийн хэмнэлтийн хуульд нийцүүлэн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлсийг олгох зорилгоор ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 26,204.7 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 24.0 хувиар нэмэгдсэн байна.

Төрийн дээд одон медаль, Засгийн газрын шагнал салбарын тэргүүний ажилтан тэмдэг, жуух бичиг, эрчим хүчний салбарын болон компанийн ажил мэргэжлийн аварга, ҮЭХ, Монголын Залуучуудын холбооны шагнал болон бусад шагналаар 105 ажилтан шагнуулж, 2025 оны компанийн бизнес төлөвлөгөө, “Хамтын гэрээ”-г үндэслэн шагнал урамшууллын зардалд 92.5 сая төгрөг зарцуулсан. Төрийн дээд одон медаль, Засгийн газрын шагнал, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын нэрэмжит шагналуудад 2025 онд давхардсан тоогоор нийт 51 ажилтан шагнуулсан байна. Үүнд:

Төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт медаль 6, Эрчим хүчний тэргүүний ажилтан Хүндэт тэмдгээр 7, Эрчим хүчний яам жуух бичгээр 13, дүүргийн ИТХ-ын шагналаар 4, Төрийн бус байгууллагын шагналаар 9 ажилтан тус тус шагнагдсан ба гүйцэтгэх захирлын шагналаар компанийн хэмжээнд 133 ажилтан шагнагдсан.

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/354 дүгээр тушаалаар “Компанийн оны аварга салбар, хөдөлмөрийн болон ажил мэргэжлийн аварга шалгаруулах журам”-ыг шинэчлэн батлууллаа.

БЗӨБЦТС ТӨХК-ийн хамтын гэрээний 2025 оны биелэлтийн мэдээ

№	Асуулт	Хамрагдсан хүний тоо	Зарцуулагдсан хөрөнгийн хэмжээ
1	Нийт ажилтны тоо	545	26,204.7
2	ҮЭ-ийн гишүүдийн тоо	545	26,204.7
3	Үүнээс – эмэгтэйчүүд - залуучууд /35 хүртэлх насны/	182 234	
4	Цалингийн сан /сая.төг/	529	24,044.1
5	Дундаж цалин /мян.төг/	1	3.39
6	Цалин хөлс нэмэгдүүлсэн хувь	544	0 хувь
7	Нэмэгдэл хөлс /сая.төг/ - шөнийн цагийн - илүү цагийн	75 193	285.6 831.1
8	Нэмэгдэл /сая.төг/ - ур чадвар - удаан жил - бусад	11 427 545	40,7 2,598.7 2,502.8
9	Шагнал урамшуулал /сая.төг/ - жилийн үр дүн - сарын үр дүн - спорт, урлаг, тэмцээнд оролцсоны - нэг удаагийн - хөдөлмөрийн баатар, гавъяат, ажил мэргэжлийн аварга, хүндэт дэвтэрт бичигдэгсдэд - өндөр насны ой	545 545 0 0 0 10 0	1,896.8 4,666.2 0 0 0 92.5 0
10	Олговор /сая.төг/ - сул зогсолтын - ҮО, МШӨ, хурц хордлого	0 0	0 0
11	Хөнгөлөлт /сая.төг/ - амралт, сувилал - унаа - хоол - түлээ нүүрс	11 103 545 454	4.3 9.0 636.8 153.7
12	Тэтгэмж /сая.төг/ - цомхотголоор халагдсаны - өндөр насны тэтгэвэрт гарсан - жирэмсэн эхчүүдэд	0 9 0	0 465.2 0
13	Тусламж /сая.төг/ - нас барагсдад - өрх толгойлсон эх, эцэгт	48 0	178.6 0
14	Хичээл заасан багшид олгосон хөлс /сая.төг/	0	0
15	Орон сууц барих, худалдан авахад зарцуулсан хөрөнгө /сая.төг/	0	0
16	Хөдөлмөр хамгааллын зардалд зарцуулсан хөрөнгө /сая.төг/	545	620.5



2.3. Хүний нөөцийн судалгаа

Ажилтнуудын дотоод бүтцийг авч үзвэл 35 хүртэлх настай 234, 35-аас дээш настай 311, эрэгтэй 363, эмэгтэй 182, дээд боловсролтой 287, тусгай дунд 96, бүрэн дунд 152, бүрэн бус дунд 10 ажилтан байна. Мэргэжлийн түвшний хувьд бакалавр зэрэгтэй 257, магистр 30, зөвлөх инженер 10, мэргэшсэн инженер 25, мэргэшсэн нягтлан бодогч 6, мэргэшсэн төсөвчин 3 тус тус ажиллаж байна.

Компанийн ажилтнуудын хүйсийн судалгаа

Д/д	Компани	Хэнтий	Говь-сүмбэр	Багануур	Дундговь	Дорноговь	Нийт	Хувь
Эрэгтэй	56	83	55	48	61	59	362	66.5
Эмэгтэй	45	33	33	19	17	35	182	33.5
Нийт	101	116	88	67	78	94	544	100

Компанийн ажилтнуудын боловсролын түвшний судалгаа

Д/д	Компани	Хэнтий	Говь-сүмбэр	Багануур	Дундговь	Дорноговь	Нийт
Магистр	16	5	1	3	4	1	30
Бакалавр	65	51	33	33	30	44	256
Бүрэн дунд	10	43	13	28	18	40	152
Бүрэн бус дунд	1	0	3	0	3	3	10
Тусгай дунд	9	17	38	3	23	6	96
Нийт	101	116	88	67	78	94	544

Компанийн ажилтнуудын ажилласан жилийн судалгаа

Ажилласан жил	Бага тушаалын ажилтан	Албан хаагч	ИТА	Удирдлага	Нийт
0-5 жил	127	24	58	2	211
6-10 жил	54	12	36	8	110
11-15 жил	43	8	24	6	81
16-20 жил	42	9	19	13	83
21-25 жил	17	2	14	4	37
26-30 жил	7	0	5	3	15
31-ээс дээш жил	3	0	4	0	7
Нийт	293	55	160	36	544

Компанийн ажилтнуудын насны ангиллын судалгаа

Насны ангилал	Бага тушаалын ажилтан	Албан хаагч	ИТА	Удирдлага	Нийт
20-35 нас	119	18	91	5	233
36-49 нас	129	29	48	28	236
50-59 нас	45	8	21	3	75
Нийт	293	55	160	36	544

2.4. Хууль, эрх зүйн чиглэлээр

Тайлант хугацаанд компанитай холбоотой дараах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Үүнд:

1.“Динатос” ХХК нь цахилгаан эрчим хүчний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тул 12301149 (арван хоёр сая гураан зуун нэгэн мянга нэг зуун дөчин ес) төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийг дүүргийн эрүү иргэний хялбар ажиллагааны анхан шатны шүүхэд тойргийн шүүхэд гаргасан.

2.Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд Багануур дулааны станц ТӨХК-иас ЦЭХ-ний төлбөр 1,133,918,020.81 (Нэг тэрбум нэг зуун гучин гурван сая есөн зуун арван найман мянга хорин төгрөг наян нэг мөнгө) төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийг тус тус гаргасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан эрх бүхий ажилтны үүргийн дагуу БЗӨБЦТС ТӨХК-ийн ТУЗ-ийн хурлаар АТГ-т хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалтыг шинэчлэн батлуулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллан, 2025 онд удирдах албан тушаалд нэр дэвшсэн нийт 32 иргэнээс ХАСУМ-ийг цахимаар хүлээн авч, АТГ-аар хянуулан холбогдох шийдвэрийг үндэслэн албан тушаалд гүйцэтгэх захирлын тушаалаар томилуулан, хуульд заасан хугацаанд ХАСХОМ-ийг цахим программаар баталгаажуулан ажилласан ба компанийн удирдах болон эрх бүхий албан тушаалтнуудын 2024 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд цахимаар хүлээн авч, холбогдох тайланг нэгтгэн ЭХЯ-нд хүргүүлж ажилласан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, компанийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ХАСХОМ гаргах үүрэг бүхий 38 ажилтанд танхим болон онлайн хосолсон хэлбэрээр сургалтыг зохион байгуулж 2025 онд АТГ-аас мэдүүлэг гаргагчдад зориулан зохион байгуулсан 4 удаагийн онлайн сургалтад холбогдох албан тушаалтнуудыг цахимаар бүрэн хамруулсан.

МУ-ын Ерөнхий сайдаас өгсөн “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 тоот албан даалгавар, “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 03 тоот албан даалгавар “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай-“ тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх Эрчим хүчний сайдын баталсан төлөвлөгөөний дагуу АТГ-д хүсэлт гарган 2025 оны 09 дүгээр сарын 10-нд компанийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудыг сургалтад бүрэн хамруулсан.

Компанийн ёс зүйн дүрмийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн шинэчлэх ажлын хэсэгт ажиллаж компанийн ажилтны ёс зүйн дүрэм, ёс зүйн дэд хороо, салбар хороодын ажиллах журмыг шинээр боловсруулан, төслийг Авлигын эсрэг хуулийн дагуу хүргүүлж ирүүлсэн саналыг дүрэм, журмын төсөлд тусган гүйцэтгэх захирлын 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн А/352 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, компанийн хэмжээнд мөрдөж ажиллаж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 4:22 минутын теле контентыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, компанийн албан ёсны олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон АТГ-ын олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, компанийн зүгээс олон нийт, залуучуудад уриалга хүргүүлж ажилласан.

2.5. Сургалтын чиглэлээр

ШУТИСургууль ЭХИС-ийн цахилгаан систем, автоматжуулалтын бакалавр зэргээр 9 ажилтныг 2.5 жилээр суралцуулж байна(2025 онд 45.0 сая төгрөг). Эрчим хүчний хөгжлийн төвийн сургалтын төвд 5 салбарын 25 монтёрыг ахисан шатны сургалтад хамруулсан. (39.8 сая төгрөг)



“Өвөр Монголын эрчим хүчний гадаад хамтын ажиллагаа” ХХК-д 21 ИТА туршлага судлах ажлыг зохион байгуулсан.(39.8 сая төгрөг)

蒙古国配网公司技术人员培训班

Professional training course for engineers of the
“Baganuur and south-east regional network of the electric distribution”
state owned stock company

2025.10.22



ХАБЭМТ, АШУУИС-иас хамтран зохион байгуулсан ХАБЭА-н сургагч багш бэлтгэх сургалтад 5 ХАБЭА-н ажилтан, мэргэжлийн зэрэг олгох ажлын хүрээнд Сургагч багш бэлтгэх сургалтад компанийн 7 инженер техникийн ажилтан хамрагдаж багшлах эрх (сертификат) авсан.



ХАБЭА-н ЗӨВЛӨГӨӨН-ийг 2025 оны 05 дугаар сарын 28-нд Хэнтий аймагт зохион байгуулж, Төв компани, 5 салбарын 280 ажилтнууд оролцож, 14 заалт бүхий зөвлөмж гарган, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



2025 оны сургалтын батлагдсан хөтөлбөрийн дагуу нийт ажилтнуудад ХАБЭА-н сургалт явуулсан. Анхан шатны шалгалт 89, ээлжит шалгалт 679, ээлжит бус 440 хамруулсан.



Компанийн хэмжээнд 2020-2025 онуудад өгөгдсөн зааварчилгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Дасгал, зааварчилгааны төрөл			2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	
1	Урьдчилсан			160	97	218	119	121	149	
2	Анхан шатны			147	97	212	133	140	212	
3	Зааварчилгаа авсан хүний тоо	Давтан	Ээлжит	Өдөр тутмын	54945	49175	84229	47252	47841	76406
4				Сарын давтан	2775	4435	4332	2357	2468	3933
5		Ээлжит бус		5900	6136	7374	2505	2487	4758	
6		Тухайлсан			11357	6136	12046	12436	12541	15566




ГУРАВ. ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар

3.1.1.Хяналт тавьж ажилласан наряд, шийдвэр:

Д/д	Наряд, шийдвэр	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
1	Наряд	1309	2037	2306	2536	2095
2	Шийдвэр	2923	3355	4963	4453	4877
Нийт		4232	5392	7269	6989	6972

Наряд шийдвэрээр хийгдсэн ажил-2020-2025 он



3.1.2.Компанийн хэмжээнд ISO 45001:2018 хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлэх:

Компанийн хэмжээнд ХЭМАБ-н менежментийн тогтолцоог нэвтрүүлэн ажлыг зохион байгуулж, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалсан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулах үүргийг хүлээн ажиллаж байна. Дээрх стандартыг Төв компани болон Багануур ЦТСС-т нэвтрүүлж, 12 дугаар сард баталгаажуулалт бүрэн хийгдсэн. Хэнтэй ЦТСС-т ISO стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж үйлчлэх хүрээгээ нэмэгдүүллээ.

3.1.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн программын талаар:

Компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагааны мэдээллийг цаг алдалгүй солилцож, мэдээний санд тулгуурлаж тайлан боловсруулж, үр дүнгийн боловсруулалтанд дүн шинжилгээ хийх боломжтой программ хангамж нэвтрүүлэх зорилгоор ХАБЭА-н программыг ашиглалтад оруулах ажил зүгшрүүлэх шатандаа явж байна.

3.1.4.Сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар:

2025 онд ЭХЯ-аас ирсэн болон компаниас харьяа салбаруудад хүргүүлсэн МЭДЭЭЛЭЛ ДААЛГАВРЫН талаар: ЭХЯ-4, ХААХ-1 нийт 5 мэдээлэл даалгаврыг харьяа салбарууд болон хэлтэс албадуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулан тайлан заасан хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

3.1.5.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн талаар

МУЗГ, ЭХЯ болон мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тухай бүр нь авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулан ажил зохион байгуулан мэргэжлийн байгууллагаас өгч буй зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. 2025 оны 03 сард гамшгаас хамгаалах үзлэгт 1 удаа амжилттай хамрагдсан ба Гамшгийн төлөвлөгөөг шинэчлэн гаргаж батлуулан ажилласан.

2025 онд Төв компани болон Багануур цахилгаан түгээх сүлжээ салбарын техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор “ДАТ КОНСАЛТИНГ” ХХК-тай хамтран Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэн онцгой байдлын ерөнхий газарт хянуулан баталгаажуулахаар өгөөд байна.

3.1.6.Галын бэлэн байдлыг хангах талаар

2025 онд дүүргийн Онцгой байдлын хэлтсээс иж бүрэн сургалт авч бэлэн байдлыг хангаж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах 4 чиглэлээр 25 ажил төлөвлөснөөс 25 ажил буюу 100% бүрэн хийж гүйцэтгэсэн.

3.2. Дотоод хяналт, шалгалт

3.2.1.Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд:

Хяналт аюулгүй ажиллагааны хэлтсээс 2025 онд “БЗӨБЦТС” ТӨХК-ийн “Хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, Шуурхай үйлчилгээ горимын хэлтэс, Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, Тоолуур хэмжүүрийн алба, Тээвэр үйлчилгээний алба, Засвар угсралт, реле хамгаалалт автоматикийн алба, Худалдан авах ажиллагаа хангамжийн алба, Мэдээлэл технологийн алба, Хэнтий ЦТСС, Говьсүмбэр ЦТСС, Дундговь ЦТСС, Багануур ЦТСС, Дорноговь ЦТС салбарууд батлагдсан график, удирдамжийн дагуу зохион байгуулж, илэрсэн зөрчлийн тайлан мэдээг тухай бүрд нь нэгтгэн гаргаж захирлын зөвлөл, тухайн хэсэг нэгжийн удирдлага, холбогдох ажилтнуудад танилцуулан, зөрчлийг арилгах зөвлөмж зөвлөгөө, албан шаардлагыг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, биелэлтийн тайланг хугацаатай авч ажилласан.

Хяналт шалгалтаар компанийн үйлчлэх хүрээний 7 аймгийн 57 сум суурин, түүний үйлчлэх хүрээний 35 дэд станц, 281 дэд өртөө (110/35/10-ын 1 дэд станц, 110/10 кВ-ын 1 дэд станц, 35/15 кВ-ын 4 дэд станц, 35/10/15 кВ-ын 1 дэд станц, 35/10 кВ-ын 16 дэд станц, 35/6 кВ-ын 8 дэд станц, 35/0.4 кВ-ын 3 дэд станц, 15/0.4 кВ-ын 24 дэд өртөө, 10/0.4 кВ-ын 113 дэд өртөө, 6/0.4 кВ-ын 142 дэд өртөө)-нүүдэд хамрагдсан.

2025 онд компанийн хэмжээнд 452 зөрчил илрүүлж, 210 зөвлөмжийг хүргүүлэн биелэлт 93%-тай, 2022 онд 1117 зөрчил илрүүлж, 580 зөвлөмжийг хүргүүлэн биелэлт 70%-тай, 2023 онд 1701 зөрчил илрүүлж, 697 зөвлөмжийг хүргүүлэн биелэлт 72%-тай, 2024 онд 484 зөрчил илрүүлж, 350 зөвлөмжийг хүргүүлэн биелэлт 89%-тай, 2025 онд 1492 зөрчил илрүүлэн, 420 зөвлөмжийг хүргүүлэн 83%-ын биелэлттэйгээр ажилласан.



Түгээх үйл ажиллагааны чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үр дүнд:

Түгээх үйл ажиллагаатай холбоотой 674 зөрчил илрүүлж, 94 зөвлөмж хүргүүлж зөвлөмжийн биелэлтийг 90.5% хэрэгжүүлэн ажилласан байна. Цахилгаан байгууламжийн ашиглалтын үеийн түвшин тогтоох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 86% байсан бол тайлангийн хэрэгжилтээр 94.0% болж сайжирсан.

Цахилгаан байгууламжийн ашиглалтын түвшин сайжирсан үзүүлэлт

№	Үзүүлэлт	Дундговь		Дорноговь		Хэнтий		Багануур		Говьсүмбэр	
		Хяналт шалгалтаар	Тайлангийн дүнгээр								
1	110/35/15/10/6 кВ д/ст	91	99	90	99	89	98	85	98	89	94
2	15/0.4, 10/0.4, 6/0.4 кВ /ТП/	91	94	89	95	79	90	86	94	88	92
3	15/0.4, 10/0.4, 6/0.4 кВ /АТП/	90	96	88	92	82	90	80	90	85	93
4	15/0.4, 10/0.4, 6/0.4 кВ /КТГН/	90	95	90	94	85	93	85	90	77	84
Дундаж үнэлгээ		91	96	90	95	84	93	84	93	85	91

- Засварын ажлын төлөвлөлтийг сайжруулах, чанар үр өгөөжийг тооцох, засварын ажлын актыг цаг хугацаанд нь бичихийг зөвлөсний дагуу “Цахилгаан тоног төхөөрөмж, барилга байгууламжид хийх засвар үйлчилгээг төлөвлөх, хяналт тавих, ашиглалтад хүлээж авах” шинэчлэн сайжруулж мөрдүүлэн засварын ажлын акт цаг хугацаандаа бичигддэг болсон байна.
- Анхан шат болон II шатны үзлэг, цахилгаан хувиарлах байгууламж, барилга байгууламж, ЦДАШ, ЦДКШ-ын ашиглалтын түвшин тогтоох үзлэгийн чанарыг дээшлүүлж салбарын ИТА нар өөрсдөө гэмтэл зөрчлөө илрүүлж, цаг хугцаа алдалгүй бүрэн устгадаг байх, тэдгээрийн ажилд компанийн холбогдох ИТА нар хяналт тавьж зөвлөдөг байх
- Хөрөнгө оруулалт, ТЗБАХ, их ба урсгал засварын төлөвлөх богино ба урт хугацааны техникийн бодлогын төлөвлөлтийг хийж, засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэх, засварын ажлыг төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, гүйцэтгэлийн актыг зохих журмын дагуу бүрдүүлэх
- Техникийн нөхцөл олгох ажлын хэсэг “Техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн ажиллах журам”-д хурлын тэмдэглэлийг тогтмол хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийг тодорхой бичиж байх. (Ажлын хэсгийн хурал ойлгомжтой, богино хугацаанд техникийн нөхцөл гарах)
- Хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийн жагсаалт шинэчлүүлж албан зөвлөмж хүргүүлэх, зөрчил арилгах ажил зохион байгуулах. (Хүн болон амьтны амь нас эрүүл мэндэд учрах эрсдэл буурна)

Хангах үйл ажиллагааны чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үр дүнд

Хангах үйл ажиллагаатай холбоотой 168 зөрчил илрүүлж, 91 зөвлөмж хүргүүлж зөвлөмжийн биелэлтийг 88.0% хэрэгжүүлэн ажилласан байна.

Үүнд:

- Хэсэг дотроо хяналт шалгалтыг зохион байгуулж ажилчдын гаргаж байгаа судалгаа, хөтлөгдөж байгаа баримт бичгийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах

- Компанийн хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс нь харьяа салбаруудад бодлогоор зөвлөж чиглүүлэх, үзлэг шалгалт хийх график төлөвлөгөө, хангах хэсгийн эзэмшил мэдлийн тоноглолын судалгаатай болох
- Цахилгаан эрчим хүчний цахим гэрээний хэрэгжилтийг хангах, цаасан гэрээг цахимд бүрэн шилжүүлэх, программын ашиглалтыг сайжруулан ажиллах
- Тоолуур нэгтгэсэн хайрцагт графикийн дагуу үзлэгийг тогтмол, чанартай хийж төлөвлөгөө гарган ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил зохион байгуулах. Үзлэгийн тайланг баримтжуулж тайлагнах ажиллах
- Шинээр орж байгаа болон сумдын борлуулалтын монтеруудад сар бүрийн дэд станцын бичилтийн баланс бодох аргыг зааж сургах, гарсан дүнг борлуулалтын инженерээр хянуулж, хэвших зөрүүтэй гарсан үр дүнд ажил зохион байгуулж баланс бариулах, тайлан бичих
- Хэрэглэгчээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэсэн тайлангийн хамт бүрдүүлж хадгалах

Худалдан авах ажиллагааны чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үр дүнд

Худалдан авах ажиллагаатай холбоотой 21 зөрчил илрүүлж, зөвлөмж хүргүүлж, шууд худалдан авалтын баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй байгааг сайжруулах, тендерийн шалгаруулалтад бараа нэг бүрийг техникийн үзүүлэлтийг үнэтэй харьцуулах, барааны нэгжийн үнэ зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй нийлүүлэгдсэн байгааг анхаарах, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн төсөв, төлөвлөгөөтэй уялдуулан харьцуулах, бараа болон ажлын нэрийг тодорхой, ойлгомжтой байдлаар өгөхийг зөвлөж ажилласан.

3.2.2. Гүйцэтгэлийн хяналт шалгалтын хүрээнд:

Хяналт аюулгүй ажиллагааны хэлтсээс 2025 онд “БЗӨБЦТС” ТӨХК-ийн “Хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Хэнтий ЦТСС, Говьсүмбэр ЦТСС, Дундговь ЦТСС, Багануур ЦТСС, Дорноговь ЦТС салбарууд батлагдсан график, удирдамжийн дагуу зохион байгуулж ажилласан.

Хяналт шалгалтаар компанийн үйлчлэх хүрээний 6 аймгийн 38 сум суурин, түүний үйлчлэх хүрээний 31 дэд станц, 198 дэд өртөө (110/35/10-ын 1 дэд станц, 110/10 кВ-ын 1 дэд станц, 35/15 кВ-ын 3 дэд станц, 35/10/15 кВ-ын 1 дэд станц, 35/10 кВ-ын 15 дэд станц, 35/6 кВ-ын 10 дэд станц, 35/0.4 кВ-ын 2 дэд өртөө, 15/0.4 кВ-ын 22 дэд өртөө, 10/0.4 кВ-ын 70 дэд өртөө, 6/0.4 кВ-ын 104 дэд өртөө)-нүүдэд түүвэрчилсэн үзлэг шалгалтыг хийсэн.

3.3.3. Гэнэтийн үзлэг шалгалтын талаар

2025 онд 5 их засвар, ТЗБАХ-ний ажилд гэнэтийн үзлэг шалгалт хийн, 3 зөрчил илрүүлж, ХАБЭА-н зөрчилд бүртгэн ажилласан



ДӨРӨВ. ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Техникийн нөхцөл олголтын талаар:

Техникийн нөхцөл олголтыг хэрэглэгчдийн хэрэглээний шинж чанар, ачааллын хэмжээ, хүчин чадлыг судалж, түгээх сүлжээний хүчин чадал, техникийн боломжийг харгалзан орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хэрэглэгчийн шугам сүлжээ, дэд станцуудыг угсруулах, модон тулгууруудыг төмөр бетон тулгуураар солих, дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын шаардлагад нийцүүлэн олгож байна. Үүнд: Тосон таслууруудыг вакуум болон элегаз, реклоузер таслуураар солиулж микропроцессорын хамгаалалттай болгох найдвартай ажиллагааг хангах, түгээх сүлжээний алдагдлыг бууруулах зорилгоор хүчний трансформаторуудыг хамгийн ашигтай горимоор ажиллаж байхаар, алдагдал багатай хүчний трансформатор тавих, салбарлаж буй шугамын эхлэл дээр скада системд холбогдох реклоузер таслуур тавих болон аюулгүй ажиллагааны үүднээс хот, төв суурин газруудад агаарын шугамыг бүрээстэй дамжуулагч утсаар, дэд өртөөг КТПН, хаалттай хуваарилах байгууламж барих зэрэг шаардлагуудыг хэрэглэгчдэд тавин ажиллаж байна.

Компанийн эзэмшлийн 6-35 кВ-ын хүчдэлийн түвшинд цахилгаан эрчим хүчинд холбуулахаар хэрэглэгч техникийн нөхцөл хүссэн албан хүсэлт ирүүлснээс 238 хэрэглэгч буюу шинээр 69.1 МВА суурилагдсан хүчин чадал бүхий техникийн нөхцөл олгож 82.5 сая.төгрөг (НӨАТ-тай) компанид төвлөрүүлсэн байна.


Техникийн нөхцөл олголтын судалгаа

Д/д	Салбарын нэр	Техникийн нөхцөлийн хүсэлт	Олгосон		Олгоогүй	Техникийн нөхцөлийн хүсэлт	Олгосон		Олгоогүй
			Тоо	Чадал МВА			Тоо	Чадал МВА	
			2024 он				2025 он		
1	Багануур	40	40	12.1	0	35	31	8.4	4
2	Говьсүмбэр	31	26	7.4	5	57	52	22.12	5
3	Дорноговь	32	30	9.8	2	55	53	15.75	2
4	Дундговь	29	28	7.4	1	27	27	61.5	0
5	Хэнтий	59	59	15.2	0	64	60	16.69	4
Нийт		191	183	52.1	8	238	223	69.17	15


Техникийн нөхцөлийг “Техникийн нөхцөл олгох журам”-ын дагуу түгээх сүлжээнд холбогдож байгаа хэрэглэгчдийг орчин үеийн дэвшилтэт, байгаль экологид сөрөг нөлөөгүй тоног төхөөрөмжөөр холбуулах шаардлагыг тавьж албан байгууллага, хувь хүний албан хүсэлтийг тухайн салбарын ерөнхий инженерүүд болон ИТА нар нь газар дээр нь судалж холболтын цэгийг шийдвэрлэж ажлын 14 хоногт багтаан шийдвэрлэж байна.

2025 оны байдлаар 6-35 кВ-ын нийт олгогдсон техникийн нөхцөлийн 79 хэрэглэгчийн 32.1 МВА суурилагдсан чадалтай хэрэглээ эрчим хүчний системд холбогдоод байна.

Олгогдсон техникийн нөхцөл болон сүлжээнд залгагдсан хэрэглэгчийн тоог өмнөх онуудтай харьцуулсан судалгаа



Олгогдсон техникийн нөхцөл болон сүлжээнд залгагдсан чадлыг өмнөх онуудтай харьцуулсан судалгаа



Хэрэглэгчид хэрэглээнийхээ чадлыг буруу тооцоолсноос дэд станцуудын чадал өндөр тавигдаж, анх захиалсан эрчим хүчээ авахгүй байдал бий болж байна. Иймээс хэрэглэгчид тохирсон хүчин чадлыг сонгох бусад заавар зөвлөмжүүдийг өгч ажиллалаа.

Техникийн нөхцөлийн дийлэнх буюу 42 хувийг 6 кВ-ын техникийн нөхцөл олголт эзэлж байна.

Олгогдсон техникийн нөхцөлийг салбар болон хүчдэлийн түвшнээр ангилсан судалгаа

Д/д	Харьяа салбар	35 кВ	22 кВ	15 кВ	10 кВ	6 кВ	Трасс өөрчлөх	Нийт
1	Дорноговь	2	1	4	41	1	4	53
2	Говьсүмбэр	8	0	1	6	36	1	52
3	Дундговь	2	0	6	9	9	1	27
4	Багануур	0	0	0	8	22	1	31
4	Хэнтий	3	0	12	18	26	1	60
6	Нийт	15	1	23	82	94	8	223


4.2. Ашиглалтын талаар:

4.2.1. Тасалдлын талаар

2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/108 тоот гүйцэтгэх захирлын тушаалаар сарын дүнгийн журмыг шинэчилсэнтэй холбогдуулан 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн А/356 тоот гүйцэтгэх захирлын тушаалаар Исайди журмыг шинээр батлан компанийн хэмжээнд дагаж мөрдөж байна.

2025 онд ТЭЗХэлтэс шинээр байгуулагдаж төлөвлөлтийг хийснээр, дотооддоо 600 минутаар баталж, шинэ журмаар тооцдог болсон нь үр дүнгээ өгсөн.


Жилд нэг хэрэглэгчдэд ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа 2025 оны дүнгээр 416.24 минут гүйцэтгэлтэй гарч төлөвлөгөөнөөс 183.4 минут бууруулж ажилласан.




4.2.2.Тасралтын тухай

2025 онд 673 тасралт гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 38.7 %-иар буурсан үзүүлэлттэй байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар



2025 оны тасралтын судалгаа



2025 онд бүртгэгдсэн тасралтын тоо (Салбараар)



Цаашид харьяа салбарууд гэмтлийн тоог багасгах, тасралт технологийн зөрчлийн тоог бууруулах, илэрсэн гэмтлүүдийг устгах ажилд шаардлагатай хөрөнгө материалын зардлуудыг төлөвлөгөөнүүдэд тусгаж зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

4.2.3.Технологийн зөрчил

Технологийн зөрчил сүүлийн 5 жилийн байдлаар



Технологийн зөрчил 2024 онд 82 удаа гарсан бол 2025 онд 28 удаа гарч, өмнөх оноос 54 нэгжээр буурсан.

Технологийн зөрчлийн тоогоор салбаруудыг жагсаавал:

- Хэнтий салбар -1 (өмнөх оноос 32 зөрчлөөр бууруулсан)
- Дорноговь салбар-9 (өмнөх оноос 4 зөрчлөөр буурсан)
- Дундговь салбар-10 (өмнөх оноос 2 зөрчлөөр буурсан)
- Говьсүмбэр салбар-5 (өмнөх оноос 15 зөрчлөөр буурсан)
- Багануур салбар-3 (өмнөх оноос 1 зөрчлөөр буурсан)



4.2.4. Гэмтлийн талаар

2025 онд гэмтлийг устгах зорилгоор гэмтэл бүрийг нэг бүрчлэн судалж үзээд түүний мөрөөр гэмтэл устгах төлөвлөгөө гаргаж компани салбарын удирдлагаар батлуулан салбаруудад хяналт тавин ажилласан. Төлөвлөгөөний дагуу компанийн хэмжээнд гэмтэл устгах ажлууд хийгдэж байна. Үүнд:

Хэнтий салбарт нийт 20 гэмтэл,
Өвлийн горим ажиллагааны саналыг боловсруулах ДҮТ ТӨХХК-ийн 2025 оны 08 дугаар сарын 18-ний өдрийн 02/1839 дугаартай албан бичгийн хавсралтын дагуу горим ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ЦДҮС ТӨХК-ийн ЗӨБ-ийн салбар болон ГБ-ийн салбаруудтай тооцоо нийлж акт үйлдэн саналыг хүргүүлж ажилласан.

“Диспетчерийн Үндэсний Төв” ТӨХХК-ийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хяналт хэмжилт явуулах тухай 02/1557 дугаартай албан бичгийн дагуу тус компанийн ТҮАХБХ-ээс хяналт хэмжилт зохион байгуулах тухай албан бичгийг харьяа салбаруудад хүргүүлсэн. Харьяа салбаруудын ТҮАХ ерөнхий инженерийн баталсан хуваарийн дагуу 2025-2026 оны өвлийн их ачааллын хэмжилтийг тус оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 0400, 1200, 1900, 2300 цагуудад компанийн түгээх болон нам хүчдэлийн хуваарилах сүлжээ, хэрэглэгчдийн эзэмшлийн дэд станцуудад хийж гүйцэтгэсэн.

Өвлийн горим ажиллагааны үед 35-110 кВ-ын дэд станцуудын ачааллын хэмжээ:

Хэмжилт хийсэн цэгүүдэд хэмжилтийн дүн, параметруудийг эмхэтгэж, манай компанийн түгээх сүлжээгээр урсан өнгөрсөн чадлыг хэмжилт хийсэн өдрөөр буюу 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хэмжилт хийгдсэн цаг тус бүрээр хүснэгт.1 болон график. 1-ээр харуулбал:

Үзүүлэлт	2024 04 цаг	2025 05 цаг	2024 12 цаг	2025 12 цаг	2024 19 цаг	2025 19 цаг	2024 23 цаг	2025 23 цаг
Чадал (МВт)	78.4	100.3	86.4	100.3	84.16	105.9	80.7	101.2



2024, 2025 оны чадлын урсгалын харьцуулалтын зөрүү	21.9 МВт	13.9 МВт	21.3 МВт	20.5 МВт
		21.8 % өссөн	13.85 % өссөн	20.1 % өссөн

Дээрхээс харахад компанийн түгээх болон нам хүчдэлийн хуваарилах сүлжээний хоногийн ачааллын графикаас урсах чадлын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэмжилт хийсэн 05, 12, 19, 23 цагуудад 13.85 – 21.8 % буюу 13.9 – 21.9 МВт чадлаар өссөн дүнтэй байна.

Компанийн хэмжээнд: Хэмжилтэд хамрагдсан харьяа салбаруудын 35 кВ-ын дэд станцуудын нийлбэр ачааллын хэмжилтийг тооцож үзвэл нийт 44 дэд станцаас 33 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс нийт дүнгээр 6.2 МВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 11 дэд станцын ачаалал 0.35 МВт чадлаар буурсан дүнтэй байна. Компанийн хэмжээнд 35 кВ-ын хэмжилтэд дэд станцуудын хувьд 5.8 МВт чадлаар өссөн үзүүлэлттэй байна.

Д/д	Салбар	Дэд станцын тоо	Суурилагдсан хүчин чадал, /кВА/	Ашиглагдаж байгаа хүчин чадал /кВт/	Ачаалал өссөн дэд станцын		Ачаалал буурсан дэд станцын	
					тоо	нийлбэр дүн /кВА/	тоо	нийлбэр дүн /кВА/
1	Дорноговь	7	50015	17.4	4	3.9995	4	1.265
2	Дундговь	14	12800	9.37	6	2.90		2.899
3	Хэнтий	9	17390	5.57	5	0.649	2	0.033
4	Багануур	6	13563	2.1	3	0.28	1	0.237
5	Говьсүмбэр	8	32750	7.245	6	1.47	2	1.327
БҮГД		44	125795	41.685	24	9.2975	9	5.761

Хэмжилтийн үр дүн 6-10 кВ хүчдэлийн түвшинд:

Компанийн эзэмшлийн 519, хэрэглэгчийн эзэмшлийн 402 агаарын болон хаалттай дэд станцуудын хүчний трансформаторын ачаалагдсан байдлыг хүснэгт-6, 7 график-8, 9-р харууллаа:

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн эзэмшлийн дэд өртөөнүүдийн ачаалагдсан байдал

Д/д	Салбар	Хэмжих нэгж	Ачаалагдсан хувь					Тасархай	Дүн, ш
			20-оос доош %	20-50 %	50-80 %	80-100 %	100-аас дээш %		



1	Багануур	ш	41	30	15	10	0	0	96
2	Говьсүмбэр	ш	32	19	11	5	4	0	71
3	Дорноговь	ш	38	38	21	9	1	0	107
4	Дундговь	ш	45	30	29	8	2		114
5	Хэнтий	ш	49	67	17	1	0	0	134
6	Компани	ш	205	184	93	33	7	0	522

4.7. Шуурхай ажиллагааны чиглэлээр


4.7.1. Тасралт, таслалтын судалгаа

2025 онд гарсан тасралт (салбар болон хүчдэлийн түвшнээр)

Д/д	Хүчдэлийн түвшин	Салбарууд					Компани	ЦДҮС ТӨХК		Нийт
		ХЭ	БН	ДУ	ДО	ГС		ЗӨБС	ГБС	
1	6 кВ	26	57	9	5	56	153	5	-	5
2	10 кВ	50	25	3	31	55	164	4	-	4
3	15 кВ	90	-	12	8	5	115	-	-	-
4	22 кВ	-	-	-	-	-	-	-	-	-
5	35 кВ	69	22	74	13	57	235	3	4	7
6	110 кВ	-	-	-	3	3	6	30	-	30
7	220 кВ	-	-	-	-	-	-	-	3	3
Нийт		235	104	98	60	176	673	42	7	49

Компанийн хэмжээнд 2025 онд бүх хүчдэлийн түвшинд нийт 722 удаагийн тасралт гарснаас 49 удаа буюу нийт тасралтын 6.8%-г “ЦДҮС” ТӨХК-ийн тасралт эзэлж байна. Компанийн ашиглалт эзэмшлийн шугам тоноглолд нийт 673 удаагийн тасралт гарсан. Үүнээс 20.3% буюу 137 удаагийн хэрэглэгчийн шугам тоноглолд гарсан тасралт. 2024 оны тасралттай харьцуулахад 376 удаагийн тасралтаар буюу 34.2%-иар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх жилүүдэд тасралтын мэдээнд АПВ амжилттай ажилласан тасралтыг оруулж тооцдог байсан бол 2025 онд тасралтын мэдээнээс хасаж тооцдог болсон нь тасралтын тоо буурсан нэг шалтгаан юм. Компанийн удирдлага мэдлийн шугам, тоноглолд 536 удаагийн тасралт гарснаас 441 тасралт нь АШ-д, 95 тасралт нь дэд станцын өндөр, нам талын оруулгад гарсан байна.

2025 оны тасралтын тоо (сараар)



Графикаас харахад 3 дугаар сараас эхлэн тасралтын тоо өссөн, 8 дугаар сараас буурсан үзүүлэлт харагдаж байна. Оны хамгийн олон тасралттай оргил сарууд нь 4, 5, 6, 7, 8-р сарууд байна. Энэ нь улирлын чанартай байгаль цаг уурын хүчтэй салхи, шуурга, түр зуурын аадар бороо, аянга цахилгаан, температурын огцом хэлбэлзэл зэрэгтэй шууд хамааралтай. 6, 7, 8-р саруудад дуу цахилгаантай ширүүн бороо, олон хоног үргэлжилсэн шиврээ бороо, түр зуурын усархаг аадар бороо их орсон. Борооноор ЦШ нэвчих, КШ-ууд буудах, ХХБ руу үерийн ус орох, өглөөний шүүдрийн цагаар тусгаарлагч нэвчих гэмтэл ихэвчлэн тохиолддог. 3, 4, 5-р сар бол салхи шуургатай, жигүүртэн амьтад үүрээ засдаг улирал учир ЦДАШ-ын дамжуулагч тасрах, орооцолдох, дамжуулагч болон төмөр хийцийн хооронд төмөр утас тохогдох, богино холбоо үүсгэх гэх мэтийн тасралтууд ихэвчлэн гарч байна.

Сүүлийн 5 жилийн тасралтын тоо, дутуу түгээсэн ЦЭХ

д/д	Нэр	Тасралтын тоо					Дутуу түгээсэн ЦЭХ (мян.кВт.ц)				
		2021	2022	2023	2024	2025	2021	2022	2023	2024	2025
1	БЗӨБЦТС ТӨХК	697	596	800	1098	722	691.7	558.2	898.8	1,340.1	942.4

Нийт тасралтын тоог 2024 оны тасралттай харьцуулахад 376 удаагийн буюу 34.2%, дутуу түгээсэн ЦЭХ 397.7 мян.кВт.ц буюу 29.6%-иар буурсан үзүүлэлт харагдаж байна. Дутуу түгээсэн ЦЭХ-ний хэмжээ буурсан гол шалтгаанууд. Үүнд:

- Тасралт нь дутуу түгээсэн ЦЭХ-ний хэмжээтэй шууд хамааралтай учир тасралтын тоо буурахад дутуу түгээлтийн хэмжээ буурсан.
- Дамжуулах компанийн тасралт нь аймгийн төвүүдийг холбосон магистрал шугамууд байдаг учраас нэг тасралтаар олон хэрэглэгч тасарч, дутуу түгээлт ихээр гардаг. Энэ жил дамжуулах компанийн тасралт өмнөх жилийнхээс 43%-иар буурсан нь бас нэг шалтгаан болсон.
- Мөн манай компани их засвар, урсгал засвар, ТЗБАХ-ний ажил, аяндын улирал, өвлийн бэлтгэл ажлуудыг төлөвлөгөөний дагуу цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн нь тасралтын тоо буурахад нөлөөлсөн.

2025 оны нийт тасралт (шалтгаанаар)

д/д	Тасралтын задаргаа, шинжилгээ, шалтгаан	Нийт		Өсөлтийн хувь
		2024	2025	
1	Хэрэглэгчийн болон гадны хүчин зүйлээс шалтгаалсан тасралт (ХЭ/ГАД)	313	248	-20.8%
2	Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруугаас (ТК/ДК)	114	49	-57.1%
3	Тоног төхөөрөмжийн гэмтлээс шалтгаалсан тасралт (ТТ)	161	125	-22.4%
4	Байгалийн гэнэтийн үзэгдлээс шалтгаалсан тасралт (БГ)	105	45	-57.2%
5	Бусад тодорхойгүй шалтгаанаас болж тасарсан тасралт (ТБ)	405	255	-37.1%
Нийт		1098	722	-34.2%




Тоон үзүүлэлтээс харахад энэ жилийн тасралтын буурсан дүнг ангиллаар харахад дамжуулах компанийн тасралт, байгалийн гэнэтийн үзэгдлээс шалтгаалсан тасралт, тодорхой бус шалтгаанаас тасарсан тасралт эдгээр ангилал дээр илүү буурсан байна. Зөвхөн компанийн удирдлага мэдлийн тоноглолд гарсан 673 удаагийн тасралтын 137 нь хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тасралт байсан. Тодорхой бус шалтгаанаар тасарсан тасралтын ихэнх хувь нь нэг удаагийн залгалтаар амжилттай залгагдаад, үзлэг хийгдээгүй тасралт эзэлж байна.

Тасралтын мөрөөр үзлэг хийсэн, хийгээгүй, үзлэгээр гэмтэл илэрсэн, илрээгүй тоон үзүүлэлт

д/д	Ангилал	110 кВ		35 кВ		22 кВ		15 кВ		10 кВ		6 кВ		Нийт	
		АШ	д/ст	АШ	д/ст	АШ	д/ст	АШ	д/ст	АШ	д/ст	АШ	д/ст		
1	Нийт тасралтын тоо	6		235		0		115		164		153		673	
2	Үзлэг хийгээгүй	-	-	75	-	-	-	48	-	57	-	75	-	255	
3	Үзлэг хийсэн	3	3	104	56	-	-	52	15	88	19	76	2	418	
3	Үзлэг хийгээд	Гэмтэл илэрсэн	1		66		0		32		48		20		167
4			Гэмтэл илрээгүй	5		94		0		35		59		58	

2025 оны нийт тасралт (үзлэгийн төрлөөр)



Нийт компанийн удирдлага мэдлийн болон хэрэглэгчийн 673 тасралт гарснаас ЦДАШ-ын тасралт 578 буюу 85.9%, дэд станцад гарсан тасралт 95 тасралт буюу 14.1%-ийг эзэлж байна. Нийт тасралтын 418 буюу 62.1%-д нь үзлэг хийсэн, 255 буюу 37.9%-д нь үзлэг хийгээгүй. Үзлэг хийсэн 418 тасралтаас 167 буюу 40%-д нь гэмтэл илрүүлсэн, 251 буюу 60%-д нь гэмтэл илрээгүй байна.

Харьяа салбаруудын хамгийн олон тасарсан шугамууд

Д/д	Шугамын нэр	Тасралтын тоо		Тайлбар
		2025	2024	
Хэнтий салбар				
1	35 кВ ГШ АШ	9	19	5 удаа үзлэг хийж, Дамжуулагчид олс тохогдсон 1, 4 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
2	15 кВ Биндэр АШ	35	25	10 удаа үзлэг хийж, 7 нь гэмтэл илрүүлсэн. Вязка тасарсан 2, КШ гэмтсэн 2, ЦШ шатсан 1, шувуу орж үрсэн 1, хэрэглэгчийн буруугаас 1, 25 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.



3	15 кВ Норовлин АШ	14	17	5 удаа үзлэг хийж, 1 нь гэмтэл илрүүлсэн. Тулгуур хугарсан 1, 10 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
4	10 кВ Бэрээвэн АШ	7	17	2 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн. ЦШ шатсан 1, дамжуулагч тасарсан 1, 5 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
5	10 кВ Хурх АШ	7	11	3 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн. ЦШ шатсан, тулгуур хугарсан 1, 4 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
6	6 кВ Төв АШ	8	10	5 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн. Дамжуулагч тасарсан 1, тусгаарлагч хагарсан 1, 3 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
Дундговь салбар				
7	35 кВ Луус АШ	10	32	8 удаа үзлэг хийж, 7 нь гэмтэл илрүүлсэн. Гирлянд хагарсан 1, гадны биет тохогдсон 3, дамжуулагч тасарсан 1,2 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй, РХ-н тавил оруулахад тасралт бассан.
8	35 кВ Гу/С АШ	15	18	10 удаа үзлэг хийж, 7 нь гэмтэл илрүүлсэн. Шувуу орж үхсэн 6, дамжуулагч траверст хүрсэн 1, 5 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
9	35 кВ Ерлөг АШ	32	20	10 удаа үзлэг хийж, 6 нь гэмтэл илрүүлсэн. Шувуу орж үхсэн 2, гадны биет тохогдсон 1, КШ гэмтсэн 2, дамжуулагч утас тасарсан 1, 22 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
Багануур салбар				
10	35 кВ ХБУ АШ	12	7	4 удаа үзлэг хийж, 1 нь гэмтэл илрүүлсэн. Бетон тулгуур хугарсан 1, 8 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
11	10 кВ ММ АШ	8	10	5 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн. ЦШ шатсан 2, 3 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
12	6 кВ Хорих АШ	14	5	8 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн. ЦШ шатсан 1, КШ гэмтсэн 1, 6 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
13	6 кВ Цэвэрлэх-2 АШ	8	9	6 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн. Дамжуулагч утас хөндлөн траверсд хүрсэн 1, КШ гэмтсэн 1, изолятор хөндийрч дамжуулагч унжсан 1, 2 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
Дорноговь салбар				
14	10 кВ Гааль АШ	5	4	4 удаа үзлэг хийж, 4 нь гэмтэл илрүүлсэн. , Г/Х шатсан 1, КШ гэмтсэн 2, шин халж хайлсан 1, 1 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
15	10 кВ Найрамдал АШ	5	1	5 удаа үзлэг хийж, 4 нь гэмтэл илрүүлсэн. КШ гэмтсэн 2, дамжуулагчид гадны биет тохогдсон 1, Дэгээ лонх мултарсан 1,
Говьсүмбэр салбар				
16	35 кВ Нисэх АШ	17	5	8 удаа үзлэг хийж, 6 нь гэмтэл илрүүлсэн. дамжуулагчид гадны биет тохогдсон 2, муур, шувуу орсон 4, 9 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
17	10 кВ НУУ АШ	13	19	12 удаа үзлэг хийж, 2 нь гэмтэл илрүүлсэн Дамжуулагч тасарсан 1, дамжуулагчид гадны биет тохогдсон 1, КШ-н гэмтэл 1, 1 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
18	10 кВ Бужгар АШ	10	13	9 удаа үзлэг хийж, 6 нь гэмтэл илрүүлсэн, КШ гэмтсэн 3, муур, шувуу орсон 2, дамжуулагчид гадны биет тохогдсон 1, 1 удаагийн тасралтад үзлэг хийгээгүй.
Нийт		229	242	



Сүүлийн 5 жилийн технологийн зөрчлийн тоо (салбар болон ангиллаар)

Д/д		Он	Салбарууд					Нийт
			ХЭ	ДО	ДУ	ГС	БН	
1	Нийт тасралт	2021	236	91	51	182	68	628
2		2022	234	67	46	101	90	538
3		2023	323	77	74	147	112	733
4		2024	337	119	152	265	111	984
5		2025	235	60	98	176	104	673
6	Аваар	2021	0	3	1	1	0	5
7		2022	8	1	0	0	0	9
8		2023	4	6	0	0	1	11
9		2024	8	6	2	5	0	21
10		2025	-	1	2	-	-	3
11	1-р зэргийн саатал	2021	9	11	2	1	1	24
12		2022	9	8	1	0	1	19
13		2023	11	7	2	3	1	24
14		2024	24	10	9	9	3	55
15		2025	1	7	7	5	3	23
16	2-р зэргийн саатал	2021	1	1	1	2	0	5
17		2022	1	0	0	0	1	2
18		2023	0	1	1	0	1	3
19		2024	1	2	1	1	1	6
20		2025	-	1	1	-	-	2
21	Нийт технологийн зөрчил	2021	10	15	4	4	1	34
22		2022	18	9	1	0	2	30
23		2023	15	14	3	3	3	38
24		2024	33	18	12	15	4	82
25		2025	1	9	10	5	3	28

Судалгаанаас харахад 2025 оны технологийн зөрчил нийт дүнгээр 54 тоогоор буюу 65.8%-иар эрс буурсан харагдаж байна. Үүний дотор аваар өмнөх оноос 18, 1-р зэргийн саатал 32, 2-р зэргийн саатал 4-р буурсан үзүүлэлттэй байна.

2025 оны таслалтын тоо (сараар болон хүчдэлийн түвшингээр)

Д/д	Сарууд	Хүчдэлийн түвшин (кВ), таслалтын тоо						Нийт
		110	35	22	15	10	6	
1	I	4	11	0	1	8	23	47
2	II	1	8	0	4	8	22	43
3	III	3	10	0	1	15	20	49
4	IV	5	60	0	13	59	40	177
5	V	0	23	0	5	21	44	93
6	VI	0	47	0	9	37	33	126
7	VII	0	47	0	11	47	62	167
8	VIII	0	14	0	9	22	28	73
9	IX	1	25	0	12	23	35	96
10	X	2	27	0	8	34	63	134
11	XI	0	10	1	7	22	44	84
12	XII	0	7	0	1	4	4	16
Нийт		16	289	1	81	300	418	1105

2025 оны 12 сарын байдлаар компанийн хэмжээнд 110 кВ-ын 16, 35 кВ-ын 289, 22 кВ-ын 1, 15 кВ-ын 81, 10 кВ-ын 300, 6 кВ-ын 418 нийт 1105 удаагийн таслалт хийгдсэн байна.

Хүснэгтээс харахад 04 дүгээр сард нийт таслалтын 16% буюу 177 удаагийн таслалт хийгдсэн нь АШ болон тоноглолд гэмтэл устгах, АУӨБА, хамгаалалт шалгах ажлууд хийгдсэнтэй холбоотой.

Мөн 06, 07 дугаар саруудад 11-15% буюу 126-167 удаагийн таслалт хийгдсэн нь УЗ, ИХ, ТЗБАХ-ний ажлууд хийгддэг.

Харин 10 дугаар сар 12% буюу 134 удаагийн таслалт хийгдсэн нь ӨБА болон тухайн жилийн төлөвлөгөөт ажлуудыг өвлийн их ачааллаас өмнө дуусгах, шинээр сүлжээнд холбогдох шинэ хэрэглэгчийн ажлууд ихээр таслалт авч хийсэн байна.

2025 оны таслалт (салбар, хүчдэлийн түвшин болон дутуу түгээлтээр)

Салбар	Хүчдэлийн түвшин (кВ), Таслалтын тоо						Нийт	ДТЦЭХ (мян.кВт.ц)
	110	35	22	15	10	6		
Багануур	0	20	0	0	48	84	152	128.77
Хэнтий	1	65	0	50	85	157	358	410.81
Дорноговь	2	27	1	12	71	18	131	268.54
Говьсүмбэр	1	125	0	1	84	106	317	481.72
Дундговь	0	47	0	18	12	47	124	255.58
ЦДҮС	12	5				6	23	2,995.1
Нийт	15	289	1	81	300	418	1105	4,540.52

Судалгаанаас харахад 2025 оны таслалт нь өмнөх 2023, 2024 оны таслалтуудаас багассан байгаа нь манай компани дэд станц шугам тоноглолын ажлуудыг зөв төлөвлөж, таслалтуудыг давхцуулан ажиллаж байгаа мөн урсгал засварын ажлуудыг найдвартай хийж, хэрэглэгчийг эрчим хүчээр хангаж ажиллаж байгаа нь харагдаж байна. Мөн “Дэлхийн банк-2” төсөл, “Чингис хаан аялал жуулчлалын бүс” багц ажлууд 2024 онд дууссан нь таслалтын тоон үзүүлэлт буурахад нөлөөлсөн.

4.7.2. Шинэ хэрэглэгчийн судалгаа

Тус компанийн хувьд 2025 онд 544 шинэ хэрэглэгч холбогдсон нь өмнөх оноос 86 хэрэглэгч буюу 18.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2025 оны шинэ хэрэглэгч (салбар болон хүчдэлийн түвшнээр)

д/д	Салбар	Хүчдэлийн түвшин					Нийт
		35 кВ	15 кВ	10 кВ	6 кВ	0.4 кВ	
1	Багануур	0	0	4	6	36	46
2	Говьсүмбэр	2	0	1	10	73	86
3	Хэнтий	2	6	6	11	141	166
4	Дорноговь	4	1	13	2	111	131
5	Дундговь	1	5	2	3	104	115
6	Нийт	9	12	26	32	465	544

2025 онд 6-35 кВ-ын хүчдэлийн түвшинд холбогдсон шинэ хэрэглэгч (салбар хүчдэлийн түвшнээр)

д/д	Он	Харьяа салбарууд					Нийт
		Говьсүмбэр	Хэнтий	Багануур	Дундговь	Дорноговь	
1	2021	6	16	13	5	2	42



2	2022	10	22	9	3	10	54
3	2023	7	26	9	5	16	55
4	2024	11	26	13	2	12	64
5	2025	13	25	10	11	20	79

4.7.3. Захиалгат ажлын талаар

2025 оны хувьд захиалгат ажлын тоо өмнөх 3 жилээс 20.3-22.08%-иар буурсан байгаа үзүүлэлт харагдаж байна. Энэ нь Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил багассан мөн ИЗА-ууд өмнөх онуудад түлхүү хийгдсэн байдлаас шалтгаалж байна.

Аваарын захиалгат ажил өмнөх онуудаас эрс буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Энэ нь шугам тоноглолын найдваржилт сайжирсан, тасралтын тоо багассан мөн ТЗБАХ, ИЗА, УЗА-ууд хугацаандаа хийгдсэнээс шалтгаалж байгаа гэж үзэж байна.

Харин эсрэгээрээ хэрэглэгчийн захиалгат ажил нэмэгдсэн үзүүлэлттэй буюу нийт захиалгын 29.5%-ийг эзэлж байна. Энэ нь БН ЦТСС, ДУ ЦТСС, ДО ЦТСС-ын хэмжээнд шинэ хэрэглэгч сүлжээнд холбогдож байгаа нь харагдаж байна.

Захиалгат ажлын тоо багассанаар тасралтын хугацаа буурч хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах найдваржилт өсч байна.


ТАВ. ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

5.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч

Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, цахилгаан эрчим хүчийг түгээх тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-иас 2025 онд 784.6 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг худалдан авсан. Өмнөх оноос 100.8 сая кВт*ц буюу 12.8%-иар, 2025 оны төлөвлөгөөнөөс 15.6 сая.кВт.ц буюу 2.0%-иар өссөн.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтоор БНХАУ-аас 2025 онд 3.1 сая.кВт*ц цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авсан. Өмнөх оноос 0.3 сая.кВт.ц-аар буюу 9.7%-иар өсч, төлөвлөгөөнөөс 0.2 сая.кВт.ц-аар илүү буюу 6.4%-иар буурсан.

ХАЦЭХ–ний төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт, сая.кВт*ц (ДҮТ ТӨХХК)



ХАЦЭХ–ний төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт мян.кВт*ц (Импорт)



Худалдан авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ өсөхөд:

- Компанийн сүүлийн 5 жилийн худалдан авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ дунджаар 11.8 хувийн өсөлттэй байна. 2021 онд 505.3 сая кВт*цаг байсан бол 2025 онд 784.6 сая кВт*цаг болж 279.3 сая кВт*цаг буюу 35.6 хувиар өссөн байна.
- Хэрэглэгчдийг ангилан үзэхэд 81%-ийг уул уурхайн олборлох баяжуулах үйлдвэр болон бусад аж ахуй нэгж байгууллагууд эзэлж байна. Айл өрхийн



хэрэглээ 19%-ийг эзэлдэг. Хэрэглэгчдийн тоо 2025 онд 59068 хүрч өнгөрсөн оноос 3118 хэрэглэгчээр буюу 5.3%-иар өссөн байна.

- Томоохон хэрэглэгчид болох уул уурхай, үйлдвэрүүдийн хэрэглээ компанийн нийт хэрэглээний 50-60 хувийг эзэлдэг. Томоохон хэрэглэгчдийн хэрэглээ жил бүр өсөлттэй байгаа учир ХАЦЭХ-ийн өсөлтөнд шууд нөлөөлж байна.
- Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифын хөнгөлөлт үзүүлж байгаатай холбогдуулан 1,2,3,11,12 саруудад гэр хорооллын айл өрхийн хэрэглээ өсөлттэй байна.

Хэрэглээний өсөлтийг хүснэгтээр харуулвал:

Д/д	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Уул уурхайн хэрэглэгчид					
1	Дөл түшиг ХХК	сая.кВт.ц	5.92	10.05	4.12
2	Багануур ХК	сая.кВт.ц	26.86	27.83	0.97
3	Олон Ихт Баян ХХК	сая.кВт.ц	15.50	16.77	1.27
4	Флюорит ланд фактори	сая.кВт.ц	1.55	2.58	1.03
5	Лут чулуу	сая.кВт.ц	1.40	3.57	2.17
6	Си Эм Кэй Ай ХХК	сая.кВт.ц	6.50	7.51	1.01
7	Хөөт ХХК	сая.кВт.ц	0.67	1.48	0.81
8	Жэй Эм Си прожектс ХХК	сая.кВт.ц	0.64	1.54	0.90
9	бусад уул уурхай	сая.кВт.ц	167.87	178.08	10.22
Нийт		сая.кВт.ц	226.90	249.40	22.50
Бусад аж ахуй нэгж байгууллагын хэрэглэгч					
1	Цэцэнс майнинг энд энерги ХХК	сая.кВт.ц	-	2.66	2.66
2	МАК ХХК	сая.кВт.ц	96.07	100.54	4.47
3	Монцемент ХХК	сая.кВт.ц	17.63	23.25	5.62
4	Төсвийн байгууллага	сая.кВт.ц	30.56	32.50	1.93
5	Бусад ААНБ	сая.кВт.ц	108.74	113.24	4.50
Нийт		сая.кВт.ц	253.01	272.19	19.18
Айл өрхийн хэрэглэгч					
1	Орон сууц	сая.кВт.ц	39.66	40.62	0.95
2	Гэр хороолол	сая.кВт.ц	74.58	82.66	8.08
Нийт		сая.кВт.ц	114.24	123.28	9.04

5.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч

2025 онд 745.1 сая кВт*цаг цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд борлуулж өнгөрсөн жилээс 100.4 сая кВт*цаг буюу 13.5 хувиар, төлөвлөгөөнөөс 3.0 сая кВт*цаг буюу 0.4 хувиар тус тус өссөн байна. Сүүлийн 5 жилд дунджаар 512.6 сая кВт*цаг цахилгаан эрчим хүч борлуулж хэрэглээний өсөлт 12.5 хувь байна.



Борлуулсан ЦЭХ (ДҮТ ТӨХХК)

Импортоор 2025 онд төлөвлөгөөгөөр 2,688 мян. кВт*ц цахилгаан эрчим хүч борлуулахаас тайлант хугацаанд 2,814.2 мян.кВт*ц буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 125.7 мян.кВтц буюу 4.5% -иар өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулсан ЦЭХ (Импорт)



5.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал

2025 оны гүйцэтгэлээр түгээлтийн алдагдал 5.03 хувь биетээр 39.4 сая кВт*ц байгаа нь төлөвлөгөөнөөс 0.39 нэгжээр, өмнөх оны гүйцэтгэлээс 0.7 нэгжээр буурсан байна.

Алдагдлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт






5.4. Цахилгаан эрчим хүчний авлага

Д/д	Ангилал	Хэмжих нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
1	Төсөв	сая.төг	0	0	0	0	0
2	ҮААГ	сая.төг	210.9	897.1	1778.3	1644.7	1407.7
3	Уул уурхай	сая.төг	580.3	1783.9	1189.6	961.7	0
4	Айл өрх	сая.төг	199.7	0	0	0	0
5	Нийт	сая.төг	990.9	2681.1	2967.9	2606.4	1407.7

Нийт авлага 1407.7 сая төгрөг буюу Багануур Дулааны станц ТӨХК-ийн авлага юм.


5.5. Хэрэглээний бүтэц, хэрэглэгчийн тоо

2025 оны байдлаар уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэр нийт хэрэглээний 35.6 хувь, бусад аж ахуй нэгж байгууллага 40.9 хувь, төсвийн байгууллага 4.5 хувь, орон сууцны айл өрхийн хэрэглээ 5.6 хувь, гэр хорооллын айл өрхийн хэрэглээ 13.3 хувийг эзэлж байна.



Уул уурхайн хэрэглээ 2024 онд 249.4 сая.кВт*ц байсан бол 2025 онд 266.5 сая.кВт*ц буюу 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Бусад аж ахуй нэгж байгууллагын хэрэглээ 2024 онд 239.7 сая.кВт*ц байсан бол 2025 онд 305.7 сая.кВт*ц буюу 21.5 хувиар өссөн. Төсвийн байгууллага 2024 онд 32.5 сая.кВт*ц байсан бол 2025 онд 33.9 сая.кВт*ц буюу 4.1 хувиар өссөн. Орон сууцны айл өрхийн хэрэглээ 2024 онд 40.6 сая.кВт*ц байсан бол 2025 онд 42.2 сая.кВт*ц буюу 3.7 хувиар өссөн. Гэр хорооллын айл өрхийн хэрэглээ 2024 онд 82.5 сая.кВт*ц байсан бол 2025 онд 99.8 сая.кВт*ц буюу 17.4 хувийн өсөлттэй байна.


Хэрэглээний бүтэц /хэрэглэгчийн ангиллаар/



Хэрэглэгчийн тоо

2025 онд хэрэглэгчийн тоо 59068. Энэ нь өмнөх оноос 3118 хэрэглэгчээр өссөн байна. Өмнөх оноосоо айл өрх 5.0 хувиар буюу 2654 хэрэглэгчээр, ҮААНБ 7.0 хувиар буюу 464 хэрэглэгчээр өссөн.

Хэрэглэгчийн тоо (ангиллаар)




5.6. Хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлт, дуудлагын судалгаа

2025 онд нийт 204 санал, гомдол хэрэглэгчдээс ирснээс хангамж, хэрэглээтэй холбоотой 45 буюу нийт саналын 22%-ийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 83 санал, хүсэлтээр буурсан байна.

Санал, гомдол (ангиллаар)

д/д	Хэрэглэгчдээс ирүүлсэн санал гомдол	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	Зөрүү
1	Цахилгаан хангамжийн чанар, хэрэглээтэй холбоотой	139	214	47	28	45	17
2	Төлбөр тооцоотой холбоотой	55	85	168	147	64	-83
3	Цахилгаан-хэмжих хэрэгсэл	3	6	27	16	18	2
4	Цахилгааны бусад	14	44	91	92	68	-24
5	Ажилтны үйл ажиллагаатай холбоотой	5	0	6	4	8	4
6	Засгийн газрын чөлөөлөлттэй холбоотой	182	0	0	0	1	1
Нийт тоо		398	349	339	287	204	-83

Дуудлагын тоо өмнөх оноос 4129 нэгжээр буурч, 32277 болсон байна.



5.7. Тоолуур, хэмжүүрийн чиглэлээр

Тус компани нь 2025 оны жилийн эцсийн байдлаар нэг фазын 38021 ш, гурван фазын 4685 ш ухаалаг тоолуур, 465 ш өгөгдөл цуглуулагчийг Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгийн төвүүд, Замын-Үүд, Бор-Өндөр сумдад суурилуулж HES системд холбогдоод байна.

Тус компанийн үйлчлэх хүрээний цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд Монгол Улсад мөрдөгдөж буй зохих стандартын шаардлага хангасан ухаалаг тоолуур, дата концентраторыг албан ёсны эрхтэй гэрээт борлуулагч хуулийн этгээдээс хүлээн авч, зах зээлд борлуулж буй үнээр аливаа нэмэлт төлбөр, зардал нэмж тооцохгүйгээр хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан тоолуур, хэмжих хэрэгслээр хангах, алслагдсан хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй түргэн шуурхай байдлаар үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд ухаалаг тоолуур зуучлалын гэрээг “ДСЦТС” ХК-тай байгуулж хамтран ажиллаж байна.

Эндлесс-Энержи ХХК-ийн ёсны борлуулах эрхтэй Holley брендийн DTSD-545S загварын 100 А-н ухаалаг тоолуур нь тус компанийн HES системд 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Тоолуурын хэмжүүрийн лабораторид туршигдаж цаашид сүлжээнд нэвтрүүлэх боломжтой нь тогтоогдсон.

Түүнчлэн үнэ төлбөргүйгээр сервер, HES систем, борлуулалт арилжааны системтэй интеграцид оруулах зардлыг бүрэн хариуцаж байгаа нь тус компанийн ажиллагаанд ихээхэн дэмжлэг үзүүлж байгаа тул цаашид хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Дээр дурьдсан шийдлүүд нь зах зээлийн шударга өрсөлдөөнийг бий болгож хэрэглэгчдэд илүү хүртээмжтэйгээр, түргэн шуурхай, хямд үнээр ухаалаг тоолуур, дата концентраторыг худалдан авах таатай нөхцөл боломжийг бүрдүүлж байна. Тус компани нь Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд ухаалаг тоолуур, өгөгдөл цуглуулагч, дагалдах программ хангамж AMI, MDM, EDIMIS системийг 2021 оны 06-р сараас эхлэн нэвтрүүлж 2024 оны 12 дугаар сард дуусгасан.

Эндлесс-Энержи ХХК-ийн инженерүүдийн хамт Хэнтий ЦТСС, Багануур ЦТС салбаруудын мэдээлэл өгөхгүй байгаа Holley брендийн ухаалаг тоолуурууд дээр зүгшрүүлэлт хийж HES системд бүртгэх ажлыг зохион байгуулсан. Уг ажлыг зохион байгуулснаар бүртгэл зүгшрүүлэлтийн хувь 45% байсныг 71% болгож нэмэгдүүлсэн.

Эрчим хүчний сайдын 2023 оны А/51, А/119 дугаар тушаал, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн в/1606 дугаар албан бичиг, ДҮТ ТӨХХК-ийн 2023 оны 1143, 02/1286, 2024 оны 02/748, 02/891, 02/10/5 дугаар албан бичгүүд, ЭХС-ийн өвлийн их ачааллын үеийн эрчим хүчний хэрэглээг бууруулах төлөвлөгөө 2.1.4, 2.5.2 заалтуудыг үндэслэж “ДҮТ” ТӨХХК-ийн <http://it-support.energy.mn/> системд тус компанийн ухаалаг тоолуурын системийг интеграцид оруулахаар программ хангамж хөгжүүлэгч “Өнөтэгш” ХХК-тай гэрээ байгуулж, уг ажлыг гүйцэтгүүлсэн.

Компанийн тоолуур хэрэглэгчдийн тоо (хэрэглээний төрлөөр)

Д/д	Хэрэглэгчийн ангилал	Ухаалаг тоолуур	Бусад тоолуур	Нийт тоолуур	Ухаалаг тоолуурын эзлэх хэмжээ (%-р)
1	Гэр хороолол	19,177	12,949	32,126	59.69%
2	Орон сууц	15,995	2,627	18,622	85.89%
3	ААНБ	5,015	4,332	9,347	53.65%
4	Нийт	40,187	19,908	60,095	66.87%

2025 онд Тоолуур хэмжүүрийн алба харьяа салбарууд, орон нутгууд дахь Стандарт хэмжил зүйн хэлтсүүдтэй хамтарч 1 болон 3 фазын нийт 1626 ширхэг тоолуурын ээлжит баталгаажуулалтыг зохион байгуулж харьяа салбаруудын дансанд нийт 13,280,800 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.



ЗУРГАА.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

6.1. Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор батлагдсан дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт, Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаал зэргийг үндэслэн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан.

2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 119 нэр төрлийн 12,132.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын 30 нэр төрлийн 9,545.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ, харьцуулалтын аргаар 36 нэр төрлийн 1,683.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ, шууд худалдан авалтаар 36 нэр төрлийн 784.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээ, ерөнхий гэрээний аргаар 1 нэр төрлийн 119 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа худалдан авахаар төлөвлөгөөнд тусгагдсан.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан 30 тендерээс 30 тендерийг амжилттай зохион байгуулж гэрээ хийн ажилласан. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан 36 тендерээс 36 тендерийг амжилттай зохион байгуулсан. 52 шууд худалдан авалтаас 20 шууд худалдан авалтын эрхийг салбарт шилжүүлэн худалдан авалт хийж 52 шууд худалдан авалтыг амжилттай зохион байгуулсан. Ерөнхий гэрээний аргаар 1 худалдан авалтыг амжилттай зохион байгуулаад байна.

Нийт 119 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж ажилласнаас 66 тендер, 1 ерөнхий гэрээний арга, 52 шууд худалдан авалтыг амжилттай зохион байгуулснаар төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувьтай ба бүх тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд багтааж хийсэн.

Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гүйцэтгэл (гэрээ байгуулсан ажлын тоогоор)



2025 оны худалдан авах ажиллагааны тайлангийн товчоо

№	Худалдан авах ажиллагааны журам	Батлагдсан нийт төсөв	Гэрээний дүн	Зөрүү хэмнэлт
1	Нээлттэй тендер шалгаруулалт	30	9,545,400,000.00	9,161,546,659.50
2	Харьцуулалтын арга	36	1,683,300,000.00	1,601,901,970.00
3	далдан авалт	52	784,400,000.00	661,696,652.00
	гэрээний арга	1	119,000,000.00	117,853,000.00
	Нийт	119	12,132,100,000.00	11,542,998,281.50

6.2. Дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг үндэслэн, 2024 онд дараах бараа бүтэгдэхүүнийг дотоодын үйлдвэрээс худалдан авсан.

2025 онд дотоодын үйлдвэрээс бараа худалдан авсан тайлан

№	Төсөл арга хэмжээний нэр, /багцын дугаар/	Санхүүжилтийн эх үүсвэр	Бараа бүтээгдэхүүний ерөнхий ангилал	Тухайн жил дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний нэр төрөл	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр, регистр
1	Төмөр бетон тулгуур	Өөрийн хөрөнгө	12.13	Инженерийн байгууламжийн төмөр бетон бүтээц, хийц хэрэгсэл, төмөр бетон тулгуур, шон	901,920,000	Хулконсалтинг групп ХХК
2	Төмөр бетон хийц	Өөрийн хөрөнгө	12.13	Инженерийн байгууламжийн төмөр бетон бүтээц, хийц хэрэгсэл, төмөр бетон тулгуур, шон	111,390,000	Хулконсалтинг групп ХХК
3	Хөдөлмөр хамгааллын хувцас	Өөрийн хөрөнгө	4.4	Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;	157,754,817	МТОТ ХХК
4	Хөдөлмөр хамгааллын гутал	Өөрийн хөрөнгө	4.4	Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;	102,985,960	Баянцагаан нуур ХХК
5	Цахилгаан дамжуулах АС, СИП утас	Өөрийн хөрөнгө	12.15	Өнгөт төмөрлөг бүтээгдэхүүн/катодын зэс, зэсийн хайлш, зэс утас, зэс голтой уян кабель, бүрээсгүй хөнгөн цагаан (ган голтой) АС утас, хөнгөн цагаан голтой бүрээстэй СИП кабель, хүчний болон хоёрдогч хэлхээний кабель, холбогч эд анги;	479,755,705	Мон Сип ХХК 6848613



6	Ажлын бээлий, бусад хэрэгсэл	Өөрийн хөрөнгө	4.4	Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;	41,088,810	Брэнд тич бридж ХХК
7	Ажлын байрны цэвэрлэгээний материал	Өөрийн хөрөнгө	11.13	Цэвэрлэгээ, үйлчилгээний зориулалттай гадаргуугийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл;	27,890,000	Фленти трейд ХХК
8	Бүх төрлийн журнал, гэрээний дэвтэр, бланк маягтууд	Өөрийн хөрөнгө	1.5	Албан бланк, дугтуй, төсвийн байгууллагын бүх төрлийн хэвлэмэл материал;	12,400,000	Соёмбопринтинг ХХК
Дотоодын үйлдвэрээс худалдан авсан барааны нийт дүн:					1,835,185,292	

6.3. Сангийн яаманд гаргасан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал

2025 оны худалдан авах ажиллагааны явцад Сангийн яаманд тендер шалгаруулалттай холбоотой 8 гомдол гарсан нь 100 хувь захиалагчийн талд шийдвэрлэгдсэн.

Д/д	ТШ-ын код	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Тендер шалгаруулалтын төрөл (Бараа, ажил, үйлчилгээ)	Нийт төсөвт өртөг (мян.төг)	Тендер шалгаруулалтын арга
1	БЗӨБЦТСТӨХК/202501020023	Компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийн хамт	Бараа	109,000.0	НТШ№25/23
2	БЗӨБЦТСТӨХК/202501020030	Ажилчдын оффис тавилга	Бараа	114,000.0	НТШ№25/30
3	БЗӨБЦТСТӨХК/202502020002	Багануур дүүргийн 0,4-10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын засварын ажлын материал	Бараа	47,000.0	ХАН№25/02
4	БЗӨБЦТСТӨХК/202502020006	Дорноговь ЦТС салбарын их засварын ажлын туслах материал	Бараа	56,000.0	ХАН№25/06
5	БЗӨБЦТСТӨХК/2025020200013	Дээврийн засварын материал	Бараа	22,700.0	ХАН№25/13
6	БЗӨБЦТСТӨХК/2025020200017	Бүх төрлийн принтерийн хор	Бараа	24,800.0	ХАН№25/17
7	БЗӨБЦТСТӨХК/2025020200025	Хөдөлмөр хамгааллын бүх төрлийн ажлын бээлий	Бараа	51,400.0	ХАН№25/25
8	БЗӨБЦТСТӨХК/2025020300030	Даатгалын үйлчилгээ	Үйлчилгээ	78,200.0	ХАН№25/30

ДОЛОО. 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

2026 онд дараах томоохон зорилтуудыг дэвшүүлж, биелэлтийг ханган ажиллахаар төлөвлөсөн. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн осол гаргалгүй ажиллах;

2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

- Компанийн дотоод дүрэм, журмуудыг цаг үеийн байдал болон доголдсон үзүүлэлттэй уялдуулж сайжруулах;
- Хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн бодлого хэрэгжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулан, олон нийтэд компанийн нэр хүндийг өсгөх.

3. Цахилгаанаар зохицуулалттай хангах, түгээх ажлын хүрээнд:

- Компанийн үйлчлэх хүрээний 4 аймгийн төв, 57 сум суурин газрын хэрэглэгчдийг 2026-2027 онд ухаалаг тоолуурын системд 100 хувь холбох ажлын I багцыг 31 сумыг ухаалаг тоолуурт холбох.